

Батлав:



Л. Баян-Алтай
Японы Хүүхдийг Ивээх Сан
Монгол дахь суурин төлөөлөгч

СОШИАЛ МЕДИАГААР КАМПАНИТ АЯН АВУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

БИДНИЙ ТУХАЙ: Хүүхдийг Ивээх Сан (ХИС) нь хүүхдийн төлөөх үйлсээрээ дэлхийд тэргүүлэгчдийн нэг, шашин, улс төрөөс ангид, олон улсын, бие даасан төрийн бус байгууллага юм. ХИС нь дэлхийн 120 улсад хүмүүнлэгийн болон хөгжлийн чиглэлийн үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Монгол Улсад 1994 оноос ажиллаж байна. Монгол Улс дахь ХИС нь Хүүхэд хамгаалал, Хүүхдийн Эрхийн Засаглал, Боловсрол, Хүүхдийн Ядуурлыг Бууруулах, Эрүүл мэнд, Хүмүүнлэгийн тусламжийн үндсэн чиглэлүүдийн дагуу ажилладаг. (Дэлгэрэнгүй мэдээллийг дараах цахим хуудаснаас уншина уу. (<https://www.savethechildren.mn/index.php/>) Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь хөтөлбөр нь “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийг нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргүүд, Говь-Алтай, Ховд аймгуудын ерөнхий боловсролын нийт 14 сургууль, 14 хамтарсан багуудыг түшиглэн 2023 оны 01 дүгээр сараас 2025 оны 12 дугаар сарын 31 -нийг дуустал 3 жилийн хугацаанд хэрэгжүүлж байна. Төсөл нь Хүүхэд хамгааллын системчилсэн механизмыг төслийн зорилтот газруудад хэрэгжүүлснээр Хамтарсан баг, сургууль, дотуур байр, эцэг эх/асран хамгаалагчид болон хүүхдүүдийг боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын асуудлаас үр дүнтэй урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах загварыг бий болгохоор зорин ажиллаж байна. “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн хүрээнд хүүхэд хамгааллын салбарт оролцоонд суурилсан засаглал, төсвийн ил тод байдлыг төлөвшүүлэх хэрэгцээ шаардлагад үндэслэн иргэдийн мэдлэг, ойлголтыг сайжруулахад чиглэсэн сошиал нөлөөллийн ажлыг зохион байгуулахаар сонгон шалгаруулалтыг зарлаж байна.

СОШИАЛ КАМПАНИТ АЖЛЫН ЗОРИЛГО: Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн чиглэлээр Монгол Улсад хүүхэд хамгааллын төсөв боловсруулах, түүнийг зарцуулах, үйлчилгээ үзүүлэх үйл явцыг ил тод, иргэдийн оролцоог хангасан, хариуцлагатай болгоход олон нийтийн мэдлэг, ойлголтыг сайжруулах сошиалд суурилсан нөлөөллийн аяныг зохион байгуулах.

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсад хүүхдийн эрхийг хамгаалах, сайн сайхан байдлыг хангах нь үндэсний хэмжээнд тэргүүлэх зорилгуудын нэг юм. Хууль, эрх зүйн орчин болон институтийн хөгжилд ахиц дэвшил гарч байгаа хэдий ч хүүхэд хамгааллын салбарт үр дүнтэй, чанартай үйлчилгээ үзүүлэх, ил тод байдлыг хангах чиглэлд бодит саад бэрхшээлүүд байсаар байна. Иргэд, иргэний нийгэм, олон нийтийн зүгээс төрийн үйлчилгээний хэрэгжилтэд хяналт тавих нөлөөлөх боломж бүхий нийгмийн эгэх хариуцлагын тогтолцоо нь хүүхдийн эрхийг хамгаалах, засаглалыг бэхжүүлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй. Хүүхэд хамгааллын салбарт оролцоонд суурилсан засаглал, төсвийн ил тод байдлыг нэвтрүүлэхийн тулд Нийгмийн эгэх хариуцлагын тогтолцоог үндэсний түвшинд төлөвшүүлэх шаардлагатай. Үүний тулд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдийн мэдлэг, ойлголтыг сайжруулах, нөлөөллийн ажлыг шат дараатайгаар зохион байгуулах хэрэгцээ бий.

Энэхүү нөлөөллийн ажил нь НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц, хүүхэд хамгааллын үндэсний хууль тогтоомж, иргэдийн оролцоотой засаглалыг дэмжсэн төвлөрлийг сааруулах шинэчлэлийн бодлого зэрэг олон улсын болон Монгол Улсын хүлээсэн үүрэг амлалтуудтай бүрэн нийцэж байна. Нөлөөллийн ажлаар

ХИС-гийн туршлагад тулгуурлан төрийн санхүүгийн менежментэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэх бөгөөд төсөв боловсруулах үйл явцад иргэдийн оролцоог дэмжих замаар хүүхдийн хэрэгцээ, эрхийг засаглалын бүх түвшинд зохих ёсоор тусгаж, нөөц бололцоогоор хангахыг зорьж байна. Ингэхдээ техник технологийн хөгжилд тулгуурлан социал нөлөөллийн ажлыг зохион байгуулах илүү үр дүнтэй гэж үзэж байна. Энэ нь үндэсний түвшинд олон нийтэд орон зай, цаг хугацаанаас үл хамааран хүүхэд хамгааллын төсөв болон түүний зарцуулалтад олон нийтийн оролцоо чухал болохыг илтгэсэн мессежийг өргөн хүрээнд далайцтай хүргэх, улмаар мэдлэг, хандлага, дадлыг өөрчлөхөд бодитой хувь нэмэр оруулах боломжийг бүрдүүлнэ.

СОШИАЛ КАМПАНИТ АЖЛЫН ТУХАЙ:

Зорилго: Монгол Улсад хүүхэд хамгааллын төсөв боловсруулах, үйлчилгээ үзүүлэх үйл явцыг ил тод, иргэдийн оролцоог хангасан, хариуцлагатай болгоход чиглэсэн мэдээллийг олон нийтэд өгөх, тэдний мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хандлага, дадлыг өөрчлөхөд бодитой хувь нэмэр оруулахдаа нийгмийн сүлжээг ашиглан үндэсний хэмжээнд нөлөөлөхөд оршино.

Кампанит ажлыг гүйцэтгэх сонирхолтой байгууллага/баг нь дараах үе шатуудыг тусгасан нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан ирүүлнэ. Үүнд:

- 1) **Эхлэлийн тайлан**– Кампанит ажлын нарийвчилсан төлөвлөгөө, зорилт, аргачлал, хуваарийг багтаасан байна.
- 2) **Контент боловсруулалт** – Төлөвлөгөөний дагуу зорилтот бүлэгт тохирсон контентуудыг боловсруулах,
- 3) **Цацалт** - Боловсруулсан контентуудыг ажлын төлөвлөгөөний дагуу олон нийтийн сүлжээгээр зорилтот бүлэгт түгээх, хандалтыг нэмэгдүүлэх.
- 4) **Явцын тайлан**- Кампанит ажлын явцын талаар хоёр долоо хоног тутам Монгол хэлээр тайлан боловсруулан төслийн багт хүргүүлэх.
- 5) **Судалгаа** - Кампанит ажлын үр дүнг үнэлэх зорилгоор зорилтот бүлгээс үр дүнгийн судалгаа авч дүн шинжилгээ хийх.
- 6) **Хяналт/Тайлагналт** – Кампанит аяны болон судалгааны үр дүнг нэгтгэсэн эцсийн тайланг Монгол, Англи хэлээр боловсруулан тайлагнах.

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй байгууллага, баг нь ажлын удирдамжид тулгуурлан кампанит ажлын үе шат бүрийг тусгасан нарийвчилсан төлөвлөгөө болон төсвийн задаргаа бүхий саналаа боловсруулан ирүүлнэ.

ЗОРИЛТОТ БҮЛЭГ: 0-18 насны хүүхэдтэй эцэг эхчүүд, асран хамгаалагчид, хүүхэд боловсролын болон хамгааллын үйлчилгээ үзүүлэгчид, мэргэжилтнүүд, шийдвэр гаргагчид, бодлого боловсруулагчид.

ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ:

Нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулахдаа дараах үндсэн шаардлагуудыг анхаарна уу. Үүнд:

Хийгдэх ажил	Тайлбар	Хугацаа
Төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> • Кампанит ажлыг хэрэгжүүлэх байгууллага, баг төслийн багаас ирүүлсэн саналд тулгуурлан кампанит ажлын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж, Хүүхдийг Ивээх Сангаар батлуулах; • Төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагааны дагуу контентын төрөл, тоо, цаг хугацаа, шалгуур үзүүлэлт, хүлээгдэж буй үр дүнг тооцсон байх, • Кампанит ажлын нэр, лого, контентын нарийвчилсан төлөвлөгөөний саналаа урьдчилан боловсруулсан байх, 	2025 оны 9 сарын 10-15

	<ul style="list-style-type: none"> • Зорилтот бүлгийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр хэдэн контент, ямар бүтээгдэхүүн боловсруулах тухай тодорхой санал төлөвлөгөөнд тусгасан байх; • Санал болгож буй контентууд нь дараах төрөл, хэлбэртэй байж болно. Тухайлбал: рийл, цахим постер, нийтлэл, богино видео, ковер арт, социал нөлөөлөгчдийн постууд, гэр бүлийн, багшийн, сурагчийн влог, амжилтын түүх, онлайн арга хэмжээ болон бусад сонирхолтой бүтээлч төрөл хэлбэртэй байж болно; • Контент тус бүр дээр хүргэх мессежийг тодорхойлсон байх; • Компанит ажил нь төслийн хүрээнд хийгдэх уламжлалт хэвлэл мэдээллийн аянтай уялдаж харилцан дэмжлэгтэйгээр хэрэгжих ёстой. <p><i>Жич: Кампанит ажлын хүрээнд боловсруулах контентод дараах хамгийн бага тооны бүтээгдэхүүн багтсан байх ёстой. Үүнд:</i></p> <ol style="list-style-type: none"> 1. Кампанит ажлын нэр бүхий лого, ковер арт, уриа үг тус бүр 1 ширхэг; 2. Постер - 5 -аас доошгүй; 3. Видео контент– 5-аас доошгүй байх (тус бүр 1-5 минутын үргэлжлэлтэй, зорилтот бүлэг рүү чиглэсэн оновчтой утга агуулгатай байх) 4. Рийлүүд, You Tube short video – 5-с доошгүй байх 5. Социал нөлөөлөгчийн пост – 3 ба түүнээс дээш. Социал нөлөөлөгчийг төслийн багийн зөвлөмжийн дагуу сонгоно) <p>Төлөвлөгөөний дагуу контентын агуулга, санаа, зохиол, сценарийг төслийн багтай хэлэлцэн боловсруулж, батлуулсан байх шаардлагатай.</p>	
<p>Контент боловсруулалт</p>	<ul style="list-style-type: none"> • Батлагдсан төлөвлөгөөний дагуу контентуудыг зохиолын дагуу боловсруулж, батлуулна. • Контентоо боловсруулахдаа хүүхдийн эрхийн зөрчилгүй байх • Насанд хүрээгүй хүний гэрэл зураг, дүрс бичлэг, аудио яриаг ашиглах бол эцэх эх, асран хамгаалагчийн болон өөрийн зөвшөөрлийг ХИС-гийн журмын дагуу авна. Хүүхдийн бүтэн овог нэр, гэр, сургуулийн хаяг зэрэг хувийн мэдээллийг оруулахгүй байх • Хүүхдийг Ивээх Сангийн Хүүхэд хамгааллын протоколын ёс зүйн дүрэмтэй танилцан түүнийг баримтлан ажиллана. • Контентуудад ашиглах ая, дуу хөгжим, дүрс зэрэг нь бүгд зохиогчийн эрхтэй байх • Фейсбүүк болон Инстаграм дээр тохирсон формат ашиглах • Бүх видео контентууд Монгол, Англи титтр болон дохионы хэлний хөрвүүлэгтэй байна. 	<p>2025 оны 9 сарын 15 - 10 сарын 10</p>
<p>Цацалт</p>	<ul style="list-style-type: none"> ▪ Боловсруулсан контентыг олон нийтийн сүлжээгээр цацах нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулах ▪ Төлөвлөгөөнд тусгагдсан бүх үйл ажиллагааг чанарын өндөр түвшинд гүйцэтгэн, төлөвлөгөөний дагуу цацах ▪ Контентуудыг батлагдсан хувилбар, төлөвлөсөн хуваарийн дагуу нэг сарын хугацаанд Save the Children in Mongolia Фейсбүүк болон Инстаграмм хуудсаар цацна. ▪ Бусад социал хуудас ба үндэсний ТВ сувгуудаар цацвал давуу талтай. 	<p>2025 оны 10 сарын 01-нээс 11 сарын 10</p>

	<ul style="list-style-type: none"> ▪ 2 долоо хоног тутмын тайланд үйл ажиллагааны хэрэгжилтийн явц болон нийт хүрсэн хүний тоог багтаана. 	
Хяналт	<ul style="list-style-type: none"> ▪ Контент тус бүрийн доор зорилтот бүлгийн өгч буй комментыг хянах, шаардлагатай тохиолдолд хариу үйлдэл үзүүлэх, чиглүүлэх арга хэмжээ авна. ▪ ХИС-гийн Хүүхэд хамгааллын протокол, ёс зүйн дүрэм, Хүүхдийн оролцооны стандартыг мөрдөж буй эсэхэд ХИС хяналт тавьж, зөвлөнө. 	2025 оны 9 сарын 15-наас 11 сарын 10
Судалгаа	<ul style="list-style-type: none"> • Кампанит ажлын үр дүнг хэмжих зорилгоор кампанит ажил дууссаны дараа зорилтот бүлгүүдээс хандлагын судалгаа авна. • Судалгааны түүврийн тоог урьдчилж тохирно. • Ажил гүйцэтгэгч судалгааны асуулга болон аргачлалаа гаргаж, Хүүхдийг Ивээх Сантай зөвлөлдөж баталгаажуулсны дараа судалгааг авна. <ul style="list-style-type: none"> ▪ Кампанит ажил дууссаны дараа судалгааны үр дүнгийн тайланг зөвлөмж хэлбэрээр англи, монгол хэл дээр боловсруулан хүлээлгэн өгнө. 	Гарааны судалгаа 2025 оны 9сарын 20-наас Барианы судалгаа 2025 оны 11 сарын 10
Тайлагналт	<ul style="list-style-type: none"> ▪ Кампанит ажлын тайланг төлөвлөсөн хугацаанд Монгол, Англи хэл дээр, Хүүхдийг Ивээх Санд хүлээлгэн өгнө. Тайлан нь кампанит ажлын үр дүнг тоон болон чанарын үзүүлэлтээр харуулсан байна. 	2025 оны 11 сарын 20-

САНАЛ АВАХ ХУГАЦАА: Дээрх ажлыг гүйцэтгэх түршлага, чадвар бүхий байгууллага/мэргэжилтнүүдийн баг 2025 оны 09 сарын 05-ны өдрийн 17.00 цагаас өмнө саналаа Хүүхдийг Ивээх Сангийн оффист битүүмжилж ирүүлнэ үү.

Ирүүлэх материал:

- Шалгаруулалтад оролцох хүсэлтийг илэрхийлсэн албан захидал
- Байгууллагын танилцуулга (байгууллагын танилцуулга, багийн гишүүдийн мэдээлэл, анкет, гол хариуцах хүний мэдээлэл)
- Ижил төстэй ажлыг зохион байгуулж байсан түршлага (мэдээлэл, жишээ болохуйц контентууд)
- Кампанит ажлыг гүйцэтгэх тухай төлөвлөгөө (тавигдах шаардлагыг үзнэ үү)
- Ажлыг гүйцэтгэх нарийвчилсан төсөв, задаргааны хамт

Гүйцэтгэгч талд тавигдах шаардлага

- Нөлөөллийн ажлын зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх удирдлага, менежмент, хүний нөөц, техникийн чадамжтай байх
- Тодорхой үр дүнд хүрсэн уламжлалт болон сошиал медиа нөлөөллийн ажил өмнө нь хийж байсан түршлагатай байх (олон улсын байгууллагуудтай ажиллаж байсан бол давуу тал болно)
- Шинэ тренд, орчин үеийн хэв маягийг контент боловсруулалтдаа тусгасан байх
- Захиалагчаас ирүүлсэн санал хүсэлт, засварыг цаг тухайд нь гүйцэтгэх хурд, чадвартай байх
- Нөлөөллийн ажлын түршид жендерийн мэдрэмжтэй, хүний эрхийг дээдэлсэн зарчмыг баримталж ажиллах
- Эрсдэлийг тооцоолон хариу арга хэмжээ авах чадвартай байх

Гүйцэтгэгч багийн бүрэлдэхүүн

а. Багийн ахлагч

Багийн ахлагчийн үүрэг:

- Сошиал нөлөөллийн ажлын үүрэг хариуцлагыг хүлээх /гэрээний заасан хугацаанд ажлыг чанартай гүйцэтгэх/
- Төслийн багтай мэдээлэл солилцох, холбоо харилцааны ажлыг хариуцаж, зохицуулах
- Багийн гишүүдээ ерөнхий удирдлагаар хангах, ажлаа төлөвлөх, үүрэг өгөх, дэмжин туслах
- Ажлын явц, үйл ажиллагааны талаар гэрээнд заагдсан хугацаанд Захиалагчид тогтмол тайлагнах

Багийн ахлагчид тавигдах шаардлага:

- Сэтгүүл зүй, олон нийттэй харилцах, маркетинг, мэдээлэл харилцаа холбооны чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх
 - Тухайн салбартаа 10-аас багагүй жил ажилласан байх, тэр дундаа 5 жилд нь удирдах, баг манлайлах үүрэг гүйцэтгэсэн бол давуу тал болно.
 - Нийгмийн чиглэлийн нөлөөллийн ажил удирдан, зохион байгуулж туршлагатай бол давуу тал болно.
 - Олон улсын байгууллага, төсөл хөтөлбөртэй хамтарч ажиллаж байсан давуу тал болно.
 - Төслийн менежмент, төлөвлөлт ба гүйцэтгэл амжилттай хэрэгжүүлсэн туршлагатай байх
 - Зохиолч/сэтгүүлч (нийгмийн хамгаалал, хүүхдийн чиглэлээр бүтээл хийж байсан бол давуу тал болно)
 - Найруулагч
 - Төсөв, төлөвлөлт, нийгмийн буюу хүүхэд хамгааллын чиглэлийн зөвлөх
- Жич: Багийн гишүүд зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй

Төслийн багийн оролцоо

Төслийн баг судалгаа хийхэд шаардлагатай зарим зөвшөөрлийг холбогдох төрийн байгууллагаас авахад дэмжлэг туслалцаа үзүүлж, контентын утга агуулга ХИС-гийн дүрэм, стандартад нийцэж буй эсэхэд зөвлөмж өгч ажиллана.

ГҮЙЦЭТГЭГЧИД ТӨЛБӨР ШИЛЖҮҮЛЭХ ХУВААРЬ

д/д	Хийгдэх ажлууд	Шилжүүлэх хувь
1	Нөлөөллийн ажлын төлөвлөгөө, аргачлал бүхий Эхлэлийн тайланг эцсийн байдлаар англи, монгол хэлээр илгээх	40%
2	Төлөвлөгөөний дагуу контент боловсруулах, Захиалагчаар батлуулах	30%
3	Нөлөөллийн ажлын Эцсийн тайлангийн анхны хувилбарыг монгол хэлээр илгээх	20%
4	Төслийн багийн санал зөвлөмжийн дагуу сайжруулсан Эцсийн тайланг эцэслэн англи, монгол хэлээр илгээх	10%